

Амбулаториор үйлчлүүлж буй настнуудийн эмийн хэрэглээний байдал

Ч.Одгэрэл

Геронтологийн үндэсний төв

Үндэслэл:

Аливаа өвчний үе эмчлүүлэгчдэд тохирох эмийг зохист тунгаар, зөв цаг хугацаанд хэрэглэх нь эмийн эмчилгээний гол зарчим юм. Настан бусад бүлгийн хүмүүсийг бодвол архаг өвчтэй, эрхтэн тогтолцооны үйл ажиллагааны алдагдалтай байдаг тул олон эмийг нэгэн зэрэг хэрэглэдэг тул эмийн гаж нөлөө болон эмийн эмчилгээний алдаанд зонхилон өртдөг эрсдэлт бүлэг юм. Настан өдөрт дунджаар 2-9 ууж байгааг эрдэмтдийн судалгааны ажлууд харуулж байна. Ахмад настнуудын дунд эмийн зохисгүй хэрэглээний тархалт 11.5-62.5% байна.

АНУ-ын настан судлаач эмч Марк Бийрс настанг эмийн гаж нөлөөнөөс урьдчилан сэргийлэх боломжтойг тооцоолон настанд гаж нөлөө ихтэй эмийн жагсаалтыг гаргаж 1991 онд анх гаргасан байна. АНУ-ын настны эмч нарийн нийгэмлэгээс энэ жагсаалтад орсон эмийн судалгаанууд хийж 1997, 2003, 2012 онд шинэчлэн сайжруулсан бөгөөд сүүлийн хувилбар нь 2015 онд халдварын эсрэг бус эмүүдийн харилцан нөлөөллийн улмаас настанд хэрэглэхээс зайлсхийх эмүүд, бөөрний үйл ажиллагааны алдагдлын үе шатаас хамааран хэрэглэхээс зайлсхийх эмүүдийг нэмэн 5 бүлэгтэй болсон байна.

Зорилго: Амбулаториор үйлчлүүлж буй настнуудын эмийн хэрэглээний байдал болон настанд эрсдэлтэй эмийн хэрэглээг судлан тогтоох

Материал арга зүй: Геронтологийн үндэсний төвийн 2020 оны 02-04 сард амбулаторийн тусламж үйлчилгээ авсан 259 настны картад ретроспектив судалгааны аргаар сүүлийн 3 сарын турш хэрэглэсэн эмийн хэрэгээний байдлыг судлав. Судалгаанд хамрагдсан настнуудын хоногт хэрэглэх эмийн хэрэглээ, эмийн сонголт, биологийн нэмэгдэл болон настны эмийн хортой, гаж нөлөө ихтэй Бийрсийн шалгуурт багтсан эмийн хэрэглээ, түүний гаж нөлөөг асуумжийн аргаар судлан тогтоосон. Статистик боловсруулалтыг SPSS 24.0 программ ашиглан хийв.

Үр дүн: Судалгаанд хамрагдсан настнуудын дундаж наслалт 64.8 ± 7.6 байсан. Эмэгтэйчүүдийн дундаж наслалт 62.4 ± 8.3 , эрэгтэйчүүдийн дундаж наслалт 69.3 ± 4.6 байсан. Судалгаанд хамрагдсан настнуудын сүүлийн 3 сарын эмийн

хэрэглээг картад болон асуумжид үндэслэн судлаад үзэхэд өдөрт дунджаар 5.3 ± 2.7 эм биологийн нэмэгдэл хэрэглэсэн байсан. Олон эмийн хэрэглээ наснаас сул шууд хамааралтай байсан ($r=0.38$, $p=0.035$), хүйс ялгаатай байдлыг судлаад үзэхэд эмэгтэй настууд дунд эм болон биологийн идэвхт бүтээгдэхүүний хэрэглээ статистик ач холбогдол бүхий их байв ($p<0.05$). геронтологийн үндэсний төвөөр үйлчлүүлсэн настуудын сүүлийн гурван сард эмнэлэгт хандалтын байдлыг судлаад үзэхэд өрхийн эмнэлэгт дунджаар 2.1 ± 0.3 удаа, аймаг болон дүүргийн эмнэлэгийн төрөлжсөн мэргэжлийн кабинетуудаар 3.8 ± 1.3 удаа, төрөлжсөн мэргэжлийн лавлагаа төвүүдээр 3.1 ± 0.9 удаа хандаж үзүүлсэн бөгөөд дунджаар 5.9 ± 2.2 төрөлжсөн мэргэжлээр үзүүлсэн байв. Төрөлжсөн мэргэжлийн эмчийн байнгийн хяналтад эм уудаг настууд 73.5%-ийг эзэлж байсан. Өвчлөлийн тэргүүлэх шалтгааныг судлаад үзэхэд зүрх судасны тогтолцооны өвчин 38.4%, мэдрэлийн эрхтэн тогтолцооны өвчин 20.1%, дотоод шүүрлийн булчирхайн өвчин 19.4%, хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эм 19.2%, яс булчингийн тогтолцооны эмгэг 13.5% тус тус эзэлж байсан. Эмийн хэрэглээг судлаад үзэхэд төрөлжсөн мэргэжлийн эмчийн хяналтын дагуу эмээ ууж байгаа настанд 59.6%, өвчин намдаах үрэвслийн эсрэг дааврын бус эм 21.7%, нянгийн эсрэг эмийн хэрэглээ 18.7%, биологийн нэмэгдэл бүтээгдэхүүн 36.5%, нойрсуулах, тайвшруулах эмийн хэрэглээ 8.4% тус тус ууж байсан. Настанд эрсдэлтэй эмийн хэрэглээний шалгуурт бичигдсэн эмийн хэрэглээ 31.5% байна. Бийрсийн шалгуураар настанд хэрэглэхэд тохиромжгүй эмийн 1 эгнээнд хэрэглэхгүй байвал зохих эрсдэлтэй эмүүдээс өвдөлт намдаах, үрэвслийн эсрэг дааврын бус эмнүүдийн хэрэглээ 32.5%, төв мэдрэлийн тогтолцоонд нөлөөлөх эмийн хэрэглээ 30.5%, ходоодны шүүрэл ялгаралтыг дарангуйлах эмийн хэрэглээ 25.3%, шээс хөөх эмийн хэрэглээ 23.4% тус тус эзэлж байна. Нянгийн эсрэг эмийн хэрэглээг нян судлалын шинжилгээнд үндэслэн сонгогдсон байдлыг судлаад үзэхэд 37.6% тай байна. Биологийн идэвхит бүтээгдэхүүнийг 63.8% реклам сурталчилгаа, 39.7% ам дамжсан яриа, 22.4% дистрибьютерийн ятгалгад үндэслэн сонгон хэрэглэсэн байна.

Дүгнэлт:

1. Үндсэн өвчний хяналтад байнга үзүүлэн эмийг эмчийн зөвлөсний дагуу хэрэглэдэг настан 73.5% байна.
2. Настан дунджаар хоногт 5.3 ± 2.7 эм, биологийн нэмэлт хэрэглэж байгаа нь олон эмийн хэрэглээтэй байгааг харуулж байна.
3. Настанд эрсдэлтэй эмийн хэрэглээний шалгуур үзүүлэлтээр үнэлээд үзэхэд 31.5% байна. Настанд эрсдэлтэй эмүүдээс үрэвслийн эсрэг дааврын бус эмнүүдийн хэрэглээ 32.5%, төв мэдрэлийн тогтолцоонд нөлөөлөх эмийн хэрэглээ 30.5%, ходоодны шүүрэл ялгаралтыг дарангуйлах эмийн хэрэглээ 25.3%, шээс хөөх эмийн хэрэглээ 23.4% тус тус хэрэглэсэн байна.
4. Настанд эрсдэлтэй эмийн хэрэглээний шалгуурт заагдсан эмийн талаарх мэдлэг жор бичиж буй эмч ч, хэрэглэж буй настанд байхгүй байна.